

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 6/79

Улаанбаатар хот

Төсөл хэрэгжүүлэгчээр батламжилж,  
гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4 дэх заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар баталсан "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.8-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/397 дугаар захирамжаар байгуулагдсан Үнэлгээний хорооны дүгнэлтийг үндэслэн Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны СТ-1, СТ-2, СТ-3 дугаар орон сууцны байрыг буулган, дахин барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчээр "Хур алтан өргөө" ХХК шалгарсныг батламжилж, газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчтэй гэрээ байгуулах эрх олгосугай.

2. Төслийн үе шатны ажлуудыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан батлуулж ажиллахыг төсөл хэрэгжүүлэгч "Хур алтан өргөө" ХХК-д даалгасугай.

3. Нарийвчилсан төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг төсөл хэрэгжүүлэгч тогтоосон хугацаанд хэрэгжүүлээгүй тохиолдолд энэхүү захирамжийг хүчингүй болгосугай.

4. Энэ захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар (Ц.Тулга)-т, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын барилга, орон сууц, үйлдвэр, технологийн паркийн асуудал хариуцсан орлогч Б.Сүхбаатарт даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР